



Цагаачдын Нийгэмлэгт Итгэлцлийг Бэхжүүлэх Бидний Амлалтууд 11 сарын 30-ны өдрийн Дугуй Ширээний Уулзалтууд Тайлангийн Хураангуй

Тойм

2021 оны 11-р сарын 30-ны өдөр Арлингтон Дүүргийн Зөвлөлийн гишүүд "Арлингтоны Цагаачдын Нийгэмлэгийн итгэлцлийг бэхжүүлэх нь" сэдвээр дугуй ширээний уулзалтыг зургаан төрлийн виртуал хэлбэрээр зохион байгууллаа. Өдрийн турш 70 гаруй оролцогчид онлайн харилцан уулзалт ярилцлагад нэгдэн оролцлоо.

Испани хэлээр гурван хэлэлцүүлэг явуулсан; Амхар болон Араб хэлний орчуулгын үйлчилгээг бусад хэлэлцүүлэгт үзүүлэх боломжтой байсан. Хэлэлцүүлэг бүрийг Дүүргийн Зөвлөлийн гишүүн удирдаж, Арлингтон Дүүргийн ахлах ажилтан дэмжин тусалцаж байв.

Оролцогчдын хувьд Перу, Гватемал, Боливи, Парагвай, Мексик, Эль Сальвадор, Этиоп болон дэлхийн бусад орнуудаас энд нүүж ирсэн Арлингтоны оршин суугчид байсан. Оролцогчдын зарим нь энд 20 гаруй жил амьдарч байгаа бол зарим нь Арлингтонд шинээр нүүж ирээд байсан. Бусад оролцогчид нь АНУ-д төрсөн өссөн боловч хөршүүдийнхээ талаар санаа зовдог оршин суугчид, Арлингтоны оршин суугчдад зориулсан шударга, тэгш бодлогууд, хөтөлбөрүүд, үйлчилгээг хөгжүүлэн дэвжүүлэх сонирхолтой өмгөөлөгчид, үйлчилгээ авахаар хайж буй гэр бүлүүдтэй идэвхтэй ажилладаг Ашгийн бус үйлчилгээ үзүүлэгчид болно.

Хэлэлцүүлэг бүрт оролцогчдоос дөрвөн гол асуудалд анхаарлаа хандуулахыг хүссэн. Үүнд:

- *Арлингтон Дүүргийн Захиргаа, тэр дотор захиргааны удирдлагууд, хууль сахиулах байгууллага болон бусад агентлагуудтай харилцахдаа хэр туршилагатай болоод байгаа бэ?*
- *Та Арлингтоны тэтгэмж болон хөтөлбөрүүдэд (жишээ нь, орон сууц, хүүхэд асрах, эрүүл мэнд/сэтгэцийн эрүүл мэнд зэрэг) хамрагдах талаар хүсэлт гаргахдаа хэр туршилагатай болоод байна вэ?*
- *Арлингтонд “аюулгүй байдал”-аа мэдрэхийн тулд танд юу хэрэгтэй вэ?*
- *Дараагийн шатанд юуны талаар анхаарах вэ?; мөн бид тантай байнга хамт байхын тулд хамтын ажиллагаа, харилцаагаа хэрхэн үргэлжлүүлэх вэ?*

11 сарын 30-ны өдөр болсон хэлэлцүүлгээр дараахь асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

Арлингтон Дүүргийн Захиргаа, Хууль сахиулах байгууллага болон бусад агентлагуудтай харилцсан Туршлага

- Оролцогчид захиргааны түвшин (Холбоо, Муж, орон нутгийн зэрэг) мөн заримдаа засгийн газар болон төрийн бус байгууллагуудын хоорондын түвшинг ялгахад

хүндрэлтэй байдаг талаараа хуваалцав. Нэг байгууллагатай холбоотой сөрөг туршлага (шериф, төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ, цагдаагийн хэлтэс, Нийгмийн үйлчилгээнүүд-----бусад бүх зүйлсийн талаарх “ойлголтод нөлөөлдөг”).

- Дүүргийн ажилтнуудтай харилцах нь тэр бүр эерэг байдаггүй бөгөөд ихэвчлэн соёлын мэдрэмж дутмаг байсан.
- Олон янзын үйлчилгээнүүд, агентлагуудтай харилцахад түвэгтэй байдаг.
- Оролцогчид хууль сахиулах байгууллагуудад итгэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ч сөрөг харилцаа нь харилцааг хурцатгаж байдгийг онцлон дурьдсан.

Тэтгэмж болон хөтөлбөрүүдэд (тухайлбал, орон сууц, хүүхэд асрах, эрүүл мэнд/сэтгэцийн эрүүл мэнд болон бусад) хамрагдах Туршлагууд

- Хоол хүнс, санхүүгийн дэмжлэг авахаар хамрагдахад тулгардаг бэрхшээлүүд.
- Хэд хэдэн оролцогчид түрээсийн төлбөр өндөр байдагтай холбоотой санхүүгийн бэрхшээлийн талаар дурьджээ.
- Тусламж авах гэж хичээх үед хэрэглэгчийн үйлчилгээ, соёлын мэдрэмж дутмаг байснаа дурьдсан.
- Үйлчилгээ авахад саад болж байсан бэрхшээл нь хэл болон орчуулга гэдгийг онцолсон.
- Оролцогчид мөн тэтгэмж авах хүсэлт гаргахад бүрдүүлдэг бичиг баримтуудын тоо, хэмжээний талаар санаа зовдгоо хуваалцав.
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах талаар тусгайлан дурьдсан.
- Гол хөтөлбөрүүд, үйлчилгээнүүдийн талаарх мэдээллийг тийм ч хялбар авах боломжгүй гэсэн мэдрэмж төрдөг.
- Тээврийн хэрэгслийн хүртээмж нь үйлчилгээнд хамрагдахад саад болдгийг мөн тодорхойлсон.

“Аюулгүй байдлыг мэдрэх” гэдэг нь ямар утгатай вэ?

- Албадан гаргах талаар санаа зовдгоо илэрхийлсэн.
- Хэрэв цагдаа нар (захиргааны аль ч түвшинд) тэдгийг зогсоох эсвэл саатуулбал юу тохиолдохыг мэдэхгүй байх айдас.
- Үйлчилгээ авахдаа мэдээлэл, бичиг баримтаа харуулах үеийн зовнил, айдас.
- Гэр бүл нь салах вий гэсэн зовнил, айдас, хүүхдүүдийг илүү мэдрэмтгий болгодог.
- Цагаачлал, Гаалийн Хяналт (ЦГХ)-ын байгууллагын талаарх зовнил, орон нутгийн хууль сахиулах байгууллага (цагдаа, шериф) болон ЦГХ-ын хоорондын харилцаа.
- Захиргааныхантай харилцах үед бие биенээ хүндлэх, итгэлцэхгүй байх мэдрэмж төрдөг.

Дараагийн шатны болон хамтын ажиллагаа/харилцаа холбоогоо үргэлжлүүлэх боломжууд

- Итгэлцлийн бодлого боловсруулах сонирхол.
- Итгэлцлийн бодлогыг ойлгуулахын тулд бүх ажилтнуудаа тогтмол сургалтанд хамруулах сонирхолтой байлгах. Бодлогыг дагаж мөрддөггүй дүүргийн ажилтан/цагдаатай харилцсан нэг сөрөг туршлага нь бидэнд итгэлцлийг бий болгоход саад болно гэсэн зовнил.
- Цагаач хүмүүстэй ажиллах, шинээр ирсэн хүмүүст зориулсан асуулт/санаа зовоосон асуудал/ лавлагаатай холбоотойгоор гол цэгт анхааран үйлчлэхэд Дүүргийн ахлах

түвшний ажилтныг ажиллуулахад зориулсан зөвлөгөөнүүд.

- Ла Colectiva-аас Дүүргийн Зөвлөлд танилцуулсан САРА (Арлингтоны Нийгэмлэгийг Хүчирхийллээс Хамгаалсан) бодлогыг авч үзэх сонирхол.
- Дүүргийн үйлчилгээнүүд, хөтөлбөрүүдэд хамрагдахын тулд олоход хялбар-соёлд ээлтэй-цэгтэй байх сонирхол.
- Арлингтон дүүргийн ажилтнууд, түүний дотор нийгмийн үйлчилгээ, цагдаа нарыг соёлын мэдрэмжийн сургалтанд хамруулах сонирхол.
- Арлингтоны цагаачдын нийгэмлэгийг нийтийг дэмжих итгэлцэл, харилцаа, үйл ажиллагааг хөгжүүлэх тухай уулзалт ярилцлагыг үргэлжлүүлэх сонирхол.
- Хүрч ажиллахын тулд олон нийтийн итгэмжит удирдлагууд болон түншүүдийг ашиглахад зориулсан зөвлөгөөнүүд.